



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/1528

Улаанбаатар хот

Түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 35 дугаар 35.2, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.23 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгийн ажиллах зааврыг хавсралтаар баталсугай.

2. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга /Т.Энхзаяа/, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Төмөрбаатар/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141202045

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед сорьц авах,
түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх
түр цэгийн ажиллах заавар

Нэг. Үндэслэл:

1.1 Коронавируст халдвар (КОВИД-19) хүн амын дунд голомт үүсгэн (кластер) байдлаар бүртгэгдэж байгаа өнөө үед нийт хүн амын дунд халдвар тархахаас урьдчилан сэргийлж, халдварын тохиолдлыг эрт илрүүлж, эрсдэлт газар нутаг, байршил, үйлчилгээний газруудаар явсан, халдварын сэжигтэй хүмүүстэй уулзсан асуумжтай иргэдийг шинжилгээнд хамруулах шаардлагатай.

1.2 Халдвар авсан байх эрсдэлтэй хүн амыг лабораторийн шинжилгээнд хамруулах, шинжилгээнд хамрагдах явцад нийтийн унаа тээвэр ашиглах, олон хүнтэй хавьтал болох эрсдлээс сэргийлж, эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус байгууллагад сорьц цуглуулах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгийг нээн ажиллуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

1.3 Тус үйл ажиллагааг Нийслэлийн эрүүл мэндийн газар удирдлага арга зүйгээр ханган ажиллана.

Хоёр. Сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгт тавигдах шаардлага:

2.1 Сорьц авахад зориулалтын бокс ашиглах эсвэл эмнэлгийн болон эмнэлгийн бус орчинд тусгай өрөө, байр бэлтгэн ашиглаж болно.

2.2 Тус байр нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, агааржуулалт сайтай, аль болох бохир цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон, халаалттай байна.

2.3 Сорьц авах, шинжилгээ хийх, хүлээлгийн, түр тусгаарлах, эмч ажилчдын байрлах хэсэгтэй байна. Орох гарах хаалга тусдаа 2 байхаар төлөвлөнө.

2.4 Төвийн үйлчлэх урсгал, бүс, тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбарыг ойлгомжтой байршуулсан байна.

Гурав. Сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгт байх хэрэгслүүд:

- 3.1. Бүртгэл хөтлөх болон сорьц шинжлэх ширээ, сандал
- 3.2. Гар угаах угаалтуур, шингэн саван, гарын цаасан алчуур
- 3.3. Гар болон орчны хатуу гадаргуу, цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх халдваргүйжүүлэх бодис
- 3.4. Цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх хэрэгсэл /хувин, алчуур зэрэг/
- 3.5. Сорьц авах болон шинжилгээ хийх хэрэгслүүд, тээвэрлэх орчин,
 - 3.5.1. Вирус зөөвөрлөх тусгай багц

- 3.5.2. 7-8 см урт уян иштэй ариун бамбар
- 3.5.3. 2-4 мл вирус зөөвөрлөх орчин бүхий бөглөөтэй хуруу шил
- 3.5.4. Сорьц зөөвөрлөх зориулалтын сав
- 3.5.5. Хэл дарагч
- 3.5.6. Цэрний сав
- 3.5.7. Хамар залгиурыг харах гэрэл
- 3.5.8. Шилний харандаа
- 3.5.9. Хуруу шилний тавиур
- 3.5.10 Сорьцын дагалдах хуудас
- 3.6. Яаралтай тусламж үзүүлэх багц,
- 3.7. Цэвэрлэгээний цомог (бөөлжих, биологийн шингэн цус, цэр, нус, өтгөн ялгадсаар бохирлогдсон үед хэрэглэх нэг удаагийн салфетка, ариун цэврийн цаас, хогийн уут, халдваргүйжүүлэх уусмалтай шүршигч сав, бээлий, маск зэрэг)
- 3.8. Зайнаас халуун хэмжигч;
- 3.9. Ахуйн болон эмнэлгийн аюултай хог цуглуулах уут, хогийн сав,
- 3.10. Орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх хэрэгсэл
- 3.11. Хамгаалах хувцас: Халад эсвэл комбинзон, эмнэлгийн нэг удаагийн амны хаалт, үзлэгийн бээлий, нүүрний хаалт, малгай, гутлын гадуурх улавч.
- 3.12. Шинжилгээг хавсралт 3-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Ажиллах баг, түүнд тавигдах шаардлага:

- 4.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгт 2 баг ажиллана..
 - 4.1.1 Түр цэгийн үйл ажиллагаанд хяналт, тандалтыг хийх багийг тархвар судлаач эмч ахалж, багийн бүрэлдэхүүнд лабораторийн мэргэжилтэн, жолооч ажиллана.
 - 4.1.2 Түр цэгт илрүүлэг шинжилгээ хийх багийг эмнэл зүйч эмч ахалж, лаборант эсвэл шинжилгээ авах сувилагч, ариутгагч, хөтөч сувилагч, үйлчилгээний ажилтан, жолооч ажиллана.
- 4.2 Багийн бүрэлдэхүүн дараах сургалтад хамрагдсан байна.
 - 4.2.1 Хамар, залгиураас сорьц авах техник эзэмшүүлэх сургалт,
 - 4.2.2 Түргэвчилсэн оношлуур ашиглах сургалт,
 - 4.2.3 Сорьц тээвэрлэх, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, бодис найруулах сургалт,
 - 4.2.4 Хамгаалах хувцас өмсөх, тайлах, гар угаах, халдваргүйжүүлэх дадлага сургалт;
 - 4.2.5 Биоаюулгүй ажиллагаа, хог хаягдлын менежментийн сургалтад хамрагдана.
- 4.3 Сургалтыг Нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.
- 4.4 Шинжлэгдэхүүн авах үед ажилтан хувийн хамгаалах хэрэгслийг журамд заасны дагуу хэрэглэх,

- 4.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хувийн бэлтгэлээ сайн хангах,
- 4.6 Ажлын цаг дууссаны дараа тусгаарлах өрөөнд байгаа хүнийг ээлжийн эмч хариуцаж, тухай өдрийн ажлыг дуусгавар болгоно.

Тав. Халдварын сэргийлэлт, хяналт:

5.1 “Заавар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537, “Түр заавар шинэчлэн батлах тухай” 2020 оны А/269 дугаар тушаалын холбогдох заалтуудыг дагаж мөрдөнө.

5.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд дараах шаардлагыг тавина.

5.2.1 Эмч, мэргэжилтэн бүрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулна.

5.2.2 Хамар, залгиураас сорьц авах, цус авахад үйлчлүүлэгч хооронд хамгаалах хувцас солих шаардлагагүй, зөвхөн гадна бээлийг солино.

5.2.3 Хамгаалах хувцсыг 4 цаг хүртэл хугацаагаар хэрэглэж болно. Бохирдсон бол тухай бүр солино.

5.2.4 Сорьц авах, шинжилгээ хийх үед гарч байгаа хог хаягдлыг ЭМС-ын 2017 оны 505 дугаар тушаалын дагуу цуглуулж “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу устгалд өгнө.

5.2.5 Хяналт, тандалтын болон илрүүлэг шинжилгээ хийх багийн бүрэлдэхүүн нь 7 хоногт 1 удаа хамар залгиурын шинжилгээг түргэвчилсэн оношлуураар хийлгэнэ. Эерэг гарсан тохиолдлыг түр тусгаарлан ХӨСҮТ-ийн 80086829 тоот утсанд мэдээлнэ.

5.3 Иргэд үйлчлүүлэх хэсэгт дараах шаардлагыг тавина.

5.3.1 Хүлээлгийн хэсэгт үйлчлүүлэгч хоорондын зай 1 м-ээс доошгүй байна. Зай барих, амны хаалт зүүхийг сануулсан анхааруулга, санамж бүхий зурагт хуудас байршуулна.

5.3.2 Үйлчлүүлэгч амны хаалт, бээлий өмссөн байна

5.3.3 Ердийн салхивчаар агааржуулалт хийгдэж байгаа бол агаар сэлгэлтийг цаг тутам хийнэ.

5.3.4 Шинжилгээгээр “эерэг” тохиолдол гарвал үйлчлүүлэгчийг түр тусгаарлах өрөөнд тусгаарлана. Бусад хүмүүстэй хавьтал болгохгүйгээр ХӨСҮТ-ийн 80086829 тоот утсанд мэдээлнэ.

5.3.5 ХӨСҮТ-ийн баг сэжигтэй тохиолдлыг ирж, зөөвөрлөнө.

5.3.6 Түр тусгаарлах өрөөнд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн баг хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийх

6.1 Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутамд хийж, шинжилгээ хийх түр цэгийг сорьц авах, шинжилгээ хийх, хүлээлгийн, түр тусгаарлах, эмч ажилчдын байрлах хэсгээр хувааж, цэвэрлэгээний хэрэгслийг тус тусад нь хэрэглэнэ. Хооронд нь хольж хэрэглэж болохгүй.

6.1.1 Хүлээлгийн хэсэгт орчны цэвэрлэгээг хийж, гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутамд хийнэ.

6.1.2 Сорьц авах, шинжилгээ хийх хэсэгт орчны цэвэрлэгээг 2 цаг тутам хийж, гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг сорьц авах, шинжилгээ хийх тухай бүрт хийнэ.

6.1.3 Түр тусгаарлах цэгт сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг тээвэрлэсний дараа голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

6.1.4 Эмч ажилчдын байрлах хэсэгт цэвэрлэгээг хийж, гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутамд хийнэ.

6.2 Сорьц авах болон шинжилгээ хийх түр цэгт цэвэрлэгээний цомог (бөөлжис, нус, цэр зэрэг биологийн шингэнээр бохирлогдсон үед хэрэглэх нэг удаагийн салфетка, ариун цэврийн цаас, хогийн уут, халдваргүйжүүлэх уусмалтай шүршигч сав, бээлий, маск зэрэг болон анхны тусламжийн эм, боолтын материал, биеийн халуун хэмжигч зэрэг) бэлтгэнэ.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУРЫН ЗААВАР

Коронавируст халдвар (КОВИД-19) вирусийн антиген илрүүлэх хурдавчилсан оношлуурын заавар /Standard Q COVID-19 Ag/

Цомгийн бүрэлдэхүүн:

1. Жаазан оношлуур- чийг шингээгч (индикаторийн өнгө нь шар байх ёстой) бүхий мөнгөлөг уутанд тусдаа савлагдсан.
2. Ялгагч буфер бүхий тубе
3. Хошуу бүхий тубений таглаа
4. Ариун бамбар
5. Заавар

Сорьц цуглуулах:

Хамар залгиурын арчдас авна.

1. Ариун бамбарыг шинжлүүлэгчийн хамрын нүхээр оруулан хамар залгиурын арын хананы гадаргуугаар хэд хэдэн удаа эргүүлэн арчиж авна. (Зааврын дагуу)
2. Арчдас авсан бамбарыг ялгагч буфер бүхий тубенд хийгээд сорьцны агуулагдахууныг бүрэн шингээж авч үлдэх зорилгоор бамбарыг тубены хананы дагуу 5-аас дээш удаа шахаж эргүүлэхдээ тубийг чимхэж шахна.
3. Арчдасны бамбарыг тубнээс буцааж авахдаа бамбараас шингэнийг бүрэн авах зорилгоор тубийг чимхэж бамбарыг сугалж авна.
4. Хошуутай таглаагаар тубийг сайтар таглана.


Сорьц зөөвөрлөх орчинтой үед:

1. Вирус тээвэрлэх орчин эсвэл сорьц цуглуулах савнаас бичил соруураар 350µl сорьцыг соруулж, ялгах буфер бүхий тубенд хийнэ. Сорьц болон ялгах буферыг соруураар сайтар холино.
2. Хошуутай таглаагаар тубийг сайтар таглана.


Сорьцыг шинжлэх:

1. Хошуу бүхий тубетэй сорьцноос 3 дуслыг жаазан оношлуурын сорьцын нүхэнд дусаана.
2. Хариуг 15-30 минутанд уншиж дүгнэнэ. 30 минутаас хойш хариуг дүгнэхгүй. Энэ нь хуурамч эерэг хариу өгөх эрсдэлтэй.


» Хариуг дүгнэх



1 Өвчтөний хамар залгиурын арчдасны сорьц авах



2 Сорьцыг ялгах буферт холих



3 Сорьцыг дусааж 30 минутанд хариуг унших

